



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 5/110

Улаанбаатар хот

Сургалтанд хамруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйл 5.1, 23 дугаар зүйлийн 23.2, компанийн 2022 оны Ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн Захиргаа удирдлагын албаны хуульч Б.Анхзаяаг Гэрээний эрх зүйн цахим сургалтанд 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд хамруулсугай.
2. Б.Анхзаяагийн сургалтын зардал болох 880,000 (найман зуун наян мянга) төгрөгийг сургалтын зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан (Т.Бямбажав)-д зөвшөөрсүгэй.
3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын алба (Б.Биндэръяа)-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.БАЛЖИННЯМ

